



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 6/23

Чингис хот

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийт Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарын ээлжийн амралтын хуваарийг 1 дүгээр, Цэцэрлэгийн эрхлэгч нарын ээлжийн амралтын хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ээлжийн амралтын хуваарь батлагдан гарсантай холбогдуулан 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, хуваарийн дагуу ээлжийн амралтаа биеэр эдлэхийг нийт захирал, эрхлэгч нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА